Open Access
БОЛОВСРОЛ сэтгүүл
Боть 2 (2026), Дугаар 1

ISSN 3007-2549

БОЛОВСРОЛ СЭТГҮҮЛ

Өгүүлэл

Дунд сургуулийн сурагчдын бие даан суралцах чадварын шинжилгээ: Танин мэдэхүй, мета танин мэдэхүй, сэтгэл хөдлөлийн чадвар

Доржхүү Отгонтуяа[1], Энхбаяр Эрдэнэтуяа[2]
[12]Ерөнхий боловсролын "Шинэ Монгол" сургууль

ХУРААНГУЙ

Өгүүллийн түүх:
Хүлээн авсан: 2026-01-14
Засварласан: 2026-02-25
Нийтэлсэн: 2026-06-04

Түлхүүр үг:
Өөрийн удирдлагатай сургалт
Танин мэдэхүйн чадвар
Мета танин мэдэхүйн чадвар
Сэтгэл хөдлөлийн чадвар

Бие даан суралцах чадварыг дунд сургуулийн сурагчдын үндсэн чадварын нэг хэмээн өргөнөөр хүлээн зөвшөөрдөг боловч түүний олон бүрэлдэхүүнт бүтэцтэй холбоотой эмпирик нотолгоо, судалгаа хангалтгүй хэвээр байна. Тодруулбал, дунд сургуулийн сурагчдын бие даан суралцах чадварыг танин мэдэхүй, мета танин мэдэхүй болон сэтгэл хөдлөлийн бүрэлдэхүүнээр нь тоон өгөгдөлд тулгуурлан судалсан судалгаа цөөн байна. Энэхүү судалгаанд Монгол Улсын хувийн хэвшлийн дунд сургуульд суралцаж буй зургаадугаар ангийн дөрвөн бүлгийн 110 сурагчийн бие даан суралцах чадварын түвшинг судлав. Судалгаанд онолын суурьтайгаар боловсруулсан бие даан суралцах чадварын өөрөө үнэлэх асуулгыг ашиглан өгөгдөл цуглуулсан. Хэмжүүрийн дотоод найдвартай байдал буюу Cronbach's $\alpha = 0.86$, дэд хэмжүүрүүдийн $\alpha = 0.75–0.82$ хооронд байв. Өгөгдөлд статистик болон нэг хүчин зүйлийн дисперсийн шинжилгээ хийж, бүлгүүдийн хоорондын ялгааг шалгав. Судалгааны үр дүнгээс харахад сурагчдын танин мэдэхүй, мета танин мэдэхүй, сэтгэл хөдлөлийн чадвар болон нийт оноо нь дөрвөн бүлгийн хувьд ойролцоо түвшинд байв. Нэг хүчин зүйлийн дисперсийн шинжилгээгээр аль ч бүрэлдэхүүнд статистикийн хувьд ач холбогдолтой ялгаа илрээгүй ($p > .05$) болно. Сэтгэл хөдлөлийн чадварын хэмжээг илэрхийлэх η^2 үзүүлэлтүүд бага утгатай гарсан нь бүлгүүдийн хооронд практик ач холбогдол бүхий ялгаа байхгүйг илэрхийлж байна. Эдгээр үр дүн нь судалгаанд хамрагдсан зургаадугаар ангийн сурагчдын бие даан суралцах чадварын олон бүрэлдэхүүнт бүтцийг эмпирик өгөгдлөөр тодорхойлсон бөгөөд судалгааны түүврийн хязгаарлалтыг харгалзан тайлбарлах шаардлагатай. Судалгааны үр дүн нь дунд сургуулийн сурагчдын бие даан суралцах чадварыг цаашид судлахад суурь мэдээлэл болно.

©2026 Author(s). This is an open access article under the CC BY 4.0 license (https://creativecommons.org/licenses/by/4.0/).

Холбоо барих зохиогч. Email: d.otgontuya@shinemongol.edu.mn
ORCID: https://orcid.org/0009-0007-4340-7846

1. УДИРТГАЛ

Орчин үеийн боловсролын тогтолцоо нь сурагчдыг зөвхөн мэдлэг эзэмшигч бус, харин насан туршдаа бие даан суралцах чадвартай, суралцах үйл явцаа өөрөө зохицуулах чадамжтай хувь хүн болгон төлөвшүүлэхэд чиглэж байна (Candy, 1991; OECD, 2018; Тогтохмаа, 2014). Ялангуяа мэдээлэл, технологи хурдацтай өөрчлөгдөж буй өнөөгийн нөхцөлд сурагчдын бие даан сурах чадвар нь сурлагын амжилт, суралцах идэвх, цаашдын боловсролын тасралтгүй хөгжилтэй шууд хамааралтай чухал хүчин зүйл болж байна (Black et al., 2006; Zimmerman, 2002).

Бие даан суралцахуй (self-directed learning) нь суралцагч өөрийн суралцах хэрэгцээг тодорхойлох, зорилго тавих, тохирох стратеги сонгох, суралцах үйл явцаа хянах, үнэлэх үйл ажиллагааг бие даан хэрэгжүүлэх цогц чадвар хэмээн тодорхойлогддог (Bishop, 2006; Candy, 1991). Судлаачид энэхүү чадварыг танин мэдэхүйн, мета танин мэдэхүйн, болон сэтгэл хөдлөлийн уялдаа холбоогоор тайлбарласаар ирсэн (Boekaerts, 1997, 1999; Panadero, 2017). Эдгээр гурван бүрэлдэхүүн нь суралцах стратеги, өөрийн ахицыг хянах, суралцах сэдэл, өөртөө итгэх итгэлээ нэмэгдүүлэх, хадгалах үйл явцад чухал үүрэг гүйцэтгэдэг (Mega et al., 2014).

Сүүлийн жилүүдэд бие даан сурах чадварыг дунд сургуулийн сурагчдын түвшинд судлах сонирхол нэмэгдэж байгаа нь энэ насны хүүхдүүдийн танин мэдэх болон мета танин мэдэх үйл ажиллагаа идэвхтэй хөгжиж, суралцах хэв маяг тогтворжиж эхэлдэгтэй холбоотой юм (Dignath & Büttner, 2018; Zimmerman & Schunk, 2011). Дунд сургууль бол бага сургуулиас ахлах сургуульд шилжих завсрын чухал үе бөгөөд сурагчид илүү бие даасан суралцах хариуцлага хүлээж эхэлдэг (Alexander et al., 1992; MacBeath, 1993). Гэвч өмнө нь хийгдсэн судалгаануудын үр дүн нь сурагчдын бие даан сурах чадварын түвшин, бүрэлдэхүүн чадваруудын харьцаа нь орчин, сургалтын арга зүй, дэмжлэгээс хамааран ялгаатай байж болохыг харуулж байна (Boekaerts, 1999; Dignath & Büttner, 2018).

Монголын боловсролын орчинд сурагчдын бие даан сурах чадварыг хөгжүүлэх бодлого, хөтөлбөрийн хүрээнд анхаарч эхэлж байгаа боловч дунд сургуулийн сурагчдын энэхүү чадварын өнөөгийн түвшинг эмпирик аргаар тодорхойлсон судалгаа хязгаарлагдмал хэвээр байгаа нь судлагдсан байдлын тоймоор нотлогдлоо. Ялангуяа бие даан сурах чадварын танин мэдэхүй, мета танин мэдэхүй, сэтгэл хөдлөлийн бүрэлдэхүүнүүдийг нэгэн зэрэг авч үзэн, тэдгээрийн түвшинг харьцуулсан судалгаа цөөн байна (Dignath & Büttner, 2018; Panadero, 2017). Монгол Улсад ерөнхий боловсролын сурагчдын бие даан суралцахуйн чиглэлээр хийгдсэн судалгааны өнөөгийн байдлыг тодорхойлох зорилгоор “Боловсрол судлал” сэтгүүлд 2001–2023 оны хооронд хэвлэгдсэн эрдэм шинжилгээний өгүүллүүдэд системчилсэн тойм судалгаа хийсэн.

Дээрх судлагдсан байдлын тоймоос харахад Монгол Улсад дунд сургуулийн сурагчдын бие даан суралцахуйн түвшинг бие даасан хэмжигдэхүүн болгон, тоон өгөгдөлд тулгуурлан судалсан эмпирик судалгаа хомс байгааг тойм судалгааны үр дүн илтгэж байна (Хавсралт 2). Иймд энэхүү судалгаа нь дунд сургуулийн сурагчдын бие даан сурах чадварын түвшинг тодорхойлох, түүний үндсэн бүрэлдэхүүн болох танин мэдэхүй, мета танин мэдэхүй болон сэтгэл хөдлөлийн чадваруудын онцлогийг эмпирик өгөгдөлд тулгуурлан шинжлэх зорилготой. Судалгааны үр дүн нь дунд

сургуулийн сургалтын орчин, арга зүйг сайжруулах, сурагчдын бие даан сурах чадварыг системтэй хөгжүүлэхэд онол, практикийн ач холбогдолтой юм.

2. СУДЛАГДСАН БАЙДЛЫН ТОЙМ

Өсвөр нас бол өөрийгөө удирдах зан үйлийн эргэлтийн цэг болж байдгаараа онцлог бөгөөд тархины хөгжлийн онолын үүднээс авч үзвэл эдгээр чадварууд нь төлөвлөх, төвлөрөх, өөрийгөө хянах, ухамсарлах, оновчтой хариу үйлдэл үзүүлэх зэргийг багтаадаг. Эдгээр чадварууд нь хүүхдийн хөгжлийн чухал алхам болох өөрийгөө удирдах чадварын үндэс суурь болдог (Байгаль, 2002).

“Бие даан суралцах" гэсэн ойлголт нь "хувь хүний сургалт", "сурагч төвтэй сургалт", "сургалт эзэмших" зэрэг орчин үеийн боловсролын үзэл баримтлал, өргөн хүрээний бодлогын хөтөлбөрүүдтэй холбоотой. Энэ нь өндөр чанартай, насан туршийн боловсрол (Тогтохмаа, 2014), нийгмийн тэгш байдал, эв нэгдлийг дэмжих сургуулийн боловсролын тогтолцоог тасралтгүй хөгжүүлэхэд "хувь хүний боловсрол"-ын чухал элементүүдийн нэг юм.

Японы нэрт сэтгэгч Фүкүзава Юкичи “бие даахуй” болон “биеэ даасан хүн”-ийг өөрийн үйлдлээ ухамсартайгаар удирдаж, бусдаас хэт хамааралгүйгээр зөв бурууг ялган таньж, өөрийн шийдвэрт хариуцлага хүлээх чадвартай хүн хэмээн тодорхойлсон нь бие даасан байдлыг зөвхөн зан үйлийн бус, үнэт зүйл, ухамсрын түвшний ойлголт болохыг илэрхийлж байна (Жаргалсайхан, 2003). Энэхүү ойлголт нь орчин үеийн боловсролын судалгаанд хэрэглэгдэж буй бие даан суралцах, өөрийн удирдлагатай суралцахуйн үзэл баримтлалтай үзэл санааны хувьд нийцэж байгаа бөгөөд суралцагчийг суралцах үйл явцдаа идэвхтэй оролцож, өөрийн зорилго, үйл ажиллагаанд хариуцлага хүлээх субъект гэж үзэх хандлагын суурийг илтгэнэ. Судлагдсан байдлын тоймоос харахад сүүлийн үеийн судлаачид бие даан суралцах чадварыг суралцагчийн зорилго тодорхойлох, суралцах үйл явцаа зохицуулах, өөрийн ахицыг хянах чадамжтай шууд холбон тайлбарлаж байгаа нь Фүкүзавагийн дэвшүүлсэн “өөрийгөө удирдах, өөрийн үйлдэлд хариуцлага хүлээх” үзэл санаа орчин үеийн судалгаанд онолын хувьд ач холбогдолтой хэвээр байна.

Бие даан суралцахуйг тодорхойлох нь

Бие даан суралцахуйг тодорхойлохдоо судлаачид олон нэр томьёо хэрэглэдэг бөгөөд тэдгээрээс хамгийн өргөн хэрэглэгддэг нь “өөрийн удирдлагатай суралцахуй” юм. Эдгээр ойлголтууд нь суралцагчийн хувь хүний онцлог, суралцах хандлага, өөрийн суралцах үйл явцад хариуцлага хүлээх бэлэн байдал, мөн багштай харилцан дэмжлэг бүхий орчинд суралцах боломж зэрэг хүчин зүйлсийг авч үздэг (Bates & Wilson, 2002; Candy, 1991; Gorman, 1998; Perry et al., 2006). Өөрийгөө зохицуулдаг суралцагчид нь аливааг өөрийн санаачилгаар эхэлдэг, тууштай, зохион байгуулалттай хүмүүс юм. Тэд зорилгодоо хүрэхийн тулд танин мэдэхүйн олон стратегийг ашигладаг төдийгүй өөрсдийн арга барил, стратегиа хянаж, эргэх холбоонд хариу өгдөг, даалгавар хүлээн авах хандлага, сурах стратегиа өөрчлөх нь бий (Орнштейн, 2003). Бие даан суралцах нь зөвхөн сурагч бие даан суралцах бус багшийн зүгээс сурагчид бие даан суралцах боломжийг олгох, дэмжихэд чухал үүрэг гүйцэтгэдэг болохыг судлаачид онцолдог. Их Британи зэрэг олон улсын судлаачид "хамааралтай" болон "бие даасан" суралцагчийн ялгааг ихэвчлэн судалдаг (Alexander et al., 1992; Boekaerts, 1997; Williams, 2003). Хамааралтай суралцагч гэдэг нь мэдлэгийг идэвхгүй хүлээн авагч

бөгөөд багшийг сургалтын үйл явцын мэргэжилтэн, өөрийн үүргийг туслах эсвэл хамааралтай гэж үздэг. Харин, бие даан суралцагч нь суралцах үйл явцыг өөрөө удирдан чиглүүлэх, зохицуулахад идэвхтэй оролцдог бөгөөд тэд бол "бие даан суралцдаг мэргэжилтэн" юм. Винне, Жэймисон-Ноэл (2002) нар багшийн оролцоогүйгээр мэдээлэл боловсруулах чадвараар нь бие даагчийг хараат суралцагчаас ялгах боломжтой гэж үздэг.

OECD-ийн судалгааны суралцах (learning to learn) чадварыг ирээдүйн хөдөлмөрийн зах зээл, насан туршийн боловсролтой шууд холбоотой хэмээн тодорхойлсон байдаг (OECD, 2018, 2021). Panadero (2017) өөрийн удирдлагатай суралцахуйн талаарх системчилсэн тойм судалгаандаа бие даан суралцахуйг танин мэдэхүй, мета танин мэдэхүй, сэдэл-сэтгэл хөдлөлийн хүчин зүйлсийн динамик харилцан үйлчлэл гэж тодорхойлсон. Энэ нь бие даан суралцахуйг зөвхөн сурагчийн "хичээлээ өөрөө хийх" үйлдлээр хязгаарлах боломжгүй, харин өөрийгөө танин мэдэх, төлөвлөх, хянах, сэтгэл хөдлөлөө зохицуулах цогц чадвар юм.

Бие даан суралцах чадварын бүрэлдэхүүн

Сүүлийн хоёр арван жилд бие даан суралцах чадварыг өсвөр насны сурагчдын суралцах хөгжлийн чухал үзүүлэлт хэмээн авч үзэх хандлага эрчимтэй нэмэгдэж байна. Судалгааны үр дүнгээс харахад дунд сургуулийн насанд танин мэдэхүй, мета танин мэдэхүй, өөрийгөө хянах үйл ажиллагаа идэвхтэй хөгжиж, суралцах хэв маяг аажмаар тогтворжих хандлагатай байдаг (Dignath & Büttner, 2018; Zimmerman & Schunk, 2011). Иймээс энэ шатанд сурагчдын бие даан суралцах чадварыг судлах нь онолын болон практикийн хувьд чухал ач холбогдолтой юм.

Орчин үеийн судалгаанд бие даан суралцахуйг суралцагчийн өөрийн зорилго тодорхойлох, суралцах үйл явцаа төлөвлөх, хэрэгжилтийг хянах, үр дүнгээ үнэлэх цогц чадвар хэмээн тодорхойлдог (Panadero, 2017). Энэхүү чадвар нь зөвхөн танин мэдэхүйн үйл ажиллагаагаар хязгаарлагдахгүй бөгөөд мета танин мэдэхүйн зохицуулалт болон сэтгэл хөдлөлийн хүчин зүйлстэй салшгүй уялдаатай болохыг эмпирик судалгаанууд нотолж байна (Dignath & Büttner, 2018; Panadero et al., 2018).

Танин мэдэхүйн чадвар

Танин мэдэхүйн чадвар нь ой санамж, анхаарал төвлөрөл, мэдээлэл боловсруулах, асуудал шийдвэрлэх зэрэг суралцах үйл ажиллагааны суурь сэтгэлзүйн процессуудыг хамардаг. Орчин үеийн судалгаанд эдгээр чадварууд нь бие даан суралцахуйн үндсэн нөхцөл болж, суралцагчид суралцах стратегийг үр дүнтэй хэрэгжүүлэх боломжийг бүрдүүлдэг болохыг тогтоосон байна (Dignath & Büttner, 2018; Panadero, 2017). Дунд сургуулийн сурагчдын хувьд танин мэдэхүйн чадвар нь унших, тэмдэглэл хөтлөх, мэдээллийг ангилан боловсруулах, суралцах арга барилаа ухамсартайгаар сонгох үйлдлээр илэрч, энэ нь бие даан суралцах чадварын суурь хэмжигдэхүүн болдог (Dignath & Büttner, 2018). Иймээс энэхүү судалгаанд танин мэдэхүйн чадварыг бие даан суралцах чадварын үндсэн бүрэлдэхүүн болгон авч үзлээ.

Мета танин мэдэхүйн чадвар

Мета танин мэдэхүйн чадвар нь суралцагч өөрийн суралцах үйл явцыг ухамсарлах, зорилго тодорхойлох, төлөвлөх, хэрэгжилтийг хянах, шаардлагатай үед стратегиа өөрчлөх чадамжийг илэрхийлдэг. Судалгааны үр дүнгээс харахад мета танин мэдэхүйн чадвар сайн хөгжсөн сурагчид суралцах үйл ажиллагаандаа илүү идэвхтэй

оролцож, бие даан суралцах түвшин өндөр байдаг (Dignath & Büttner, 2018; Panadero, 2017). Мөн мета танин мэдэхүйн зохицуулалт нь суралцагчийг өөрийн суралцах үр дүнд хариуцлагатай хандах, тасралтгүй сайжрах үйл явцад чиглүүлэх чухал хүчин зүйл болохыг судалгаанууд нотолж байна (Efklides, 2019). Иймээс уг судалгаанд мета танин мэдэхүйн чадварыг бие даан суралцах чадварын гол зохицуулагч хэмжигдэхүүн хэмээн үзсэн.

Сэтгэл хөдлөлийн чадвар

Сэтгэл хөдлөлийн чадвар нь суралцах хүсэл эрмэлзэл, тэсвэр тэвчээр, сэтгэл хөдлөлийн зохицуулалт зэрэг суралцах үйл ажиллагааг дэмжих нөлөөллийн хүчин зүйлсийг хамардаг. Судалгаануудын дүгнэлтээс харахад сэтгэл хөдлөлийн зохицуулалт нь танин мэдэхүйн болон мета танин мэдэхүйн стратегийн бодит хэрэглээг дэмжиж, бие даан суралцах үйл явцыг тогтвортой хадгалахад чухал үүрэгтэй байдаг (Mega et al., 2014; Panadero, 2017). Иймээс сэтгэл хөдлөлийн чадварыг бие даан суралцах чадварын салшгүй бүрэлдэхүүн хэмээн үзэж, бусад чадвартай уялдуулан авч үзэх шаардлагатай гэж сүүлийн үеийн судалгаанд онцолж байна. OECD-ийн боловсролын судалгаанд суралцагчийн өөрийн удирдлагатай суралцах, зорилготой сурах, “сурахад суралцах” чадваруудыг ирээдүйн хөдөлмөрийн зах зээл болон насан туршийн боловсролын суурь чадамж хэмээн тодорхойлсон байдаг (OECD, 2018, 2021). Энэ нь бие даан суралцах чадварыг зөвхөн сургалтын үр дүн бус, хувь хүний тогтвортой хөгжилтэй холбон ойлгох шаардлагатайг харуулж байна.

2015 оноос хойших судалгаануудад сурагчдын танин мэдэхүйн чадвар (ой санамж, анхаарал төвлөрөл, асуудал шийдвэрлэх) нь бие даан суралцахуйн суурь нөхцөл болохыг онцолсон байна (Dignath & Büttner, 2018). Гэвч зөвхөн танин мэдэхүйн чадвар өндөр байх нь бие даан суралцах амжилтыг илэрхийлэхэд хангалттай биш гэдгийг олон судалгаа онцолжээ. Судлаач Efklides (2019) мета танин мэдэхүйн хяналт, өөрийн суралцах үйл явцыг ухамсарлах чадвар нь сурагчид стратегиа сонгох, алдаагаа засах, зорилгоо дахин тодорхойлоход гол үүрэгтэй болохыг нотолсон. Ялангуяа дунд сургуулийн насанд сурагчид өөрийгөө хянах, суралцах үйл явцаа удирдах чадварын жигд бус хөгжил ажиглагддаг нь сургалтын орчны дэмжлэг чухал болохыг илэрхийлж байна. Судлаач Hattie (2015)-ийн мета-анализ судалгаанд өөрийн суралцах үйл явцаа ойлгож, хянах чадвар нь суралцах үр дүнд дунд-өндөр нөлөө (effect size ≈ 0.6) үзүүлдэг хүчин зүйлсийн нэг болохыг тогтоосон нь мета танин мэдэхүйн чадварыг сургалтын бодлогын түвшинд анхаарах шаардлагатайг бататгаж байна.

Mega нарын (2014) судалгаанд сэтгэл хөдлөлөө зохицуулах чадвар сул сурагчид танин мэдэхүйн стратеги сайн эзэмшсэн ч бие даан суралцах үйл явц тасалдах магадлал өндөр байдаг болохыг харуулжээ. Энэ нь бие даан суралцахуй бол оюуны чадварын болон сэтгэл хөдлөлийн хөгжлийн харилцан хамааралтай асуудал болохыг нотолж байна.

Бие даан суралцахуйг хэмжих арга зүй

Сүүлийн үеийн судалгаанд бие даан суралцахуйг танин мэдэхүй, мета танин мэдэхүй болон сэтгэл хөдлөлийн чадваруудын уялдаа холбоонд суурилсан олон хэмжигдэхүүнт цогц чадвар хэмээн үзэх хандлага давамгайлж байна (Panadero, 2017; Zimmerman, 2002). Үүнтэй уялдан бие даан суралцах чадварыг хэмжихдээ эдгээр бүрэлдэхүүнүүдийг нэгэн зэрэг хэмжих хэрэгцээ нэмэгдэж байна. Эмпирик судалгаануудад бие даан суралцахуйг ихэвчлэн өөрөө үнэлэх асуулгаар хэмждэг

бөгөөд эдгээр асуулга нь суралцагчийн танин мэдэхүйн стратегийг хэрэглэх байдал, мета танин мэдэхүйн зохицуулалт, суралцах сэдэл, сэтгэл хөдлөлийн зохицуулалтыг хамарсан бүтэцтэй байдаг (Panadero et al., 2018; Schunk & Zimmerman, 2016). Ийм хэмжүүр нь сурагчдын бие даан суралцах чадварыг системтэй, харьцуулах боломжтой байдлаар үнэлэх давуу талтай.

Хэмжүүрийн найдвартай байдлыг үнэлэхэд Cronbach's α коэффициентыг өргөн ашигладаг бөгөөд $\alpha \geq 0.70$ байх нь боловсролын судалгаанд хүлээн зөвшөөрөгдөх доод шалгуур гэж үздэг (Nunnally & Bernstein, 1994; Tavakol & Dennick, 2011). Найдвартай байдлын энэхүү шалгуур нь бүлэг хоорондын ялгааг тайлбарлах, үр дүнг үндэслэлтэй дүгнэхэд чухал ач холбогдолтой. Барууны орнуудад, ялангуяа АНУ болон Европт бие даан суралцах чадварыг хэмжих судалгаа өргөн хийгдсэн бөгөөд Их Британид хийгдсэн системчилсэн тойм судалгаанууд нь суралцах үйл явцад суурилсан хэмжилтийн арга зүйн ач холбогдлыг онцолдог (EPPI-Centre, 2004, 2005). Судлагдсан байдлын тоймоос харахад Монгол Улсад дунд сургуулийн сурагчдын бие даан суралцахуйн түвшинг бие даасан хэмжигдэхүүн болгон, тоон өгөгдөлд тулгуурлан судалсан эмпирик судалгаа хомс байгааг тойм судалгааны үр дүн илтгэж байна. (Хавсралт 2)

3. СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ

Судалгаанд оролцогчид

Энэхүү судалгаанд Монгол Улсын хувийн хэвшлийн ерөнхий боловсролын "Шинэ Монгол" сургуулийн 6-р ангийн дөрвөн бүлгийн нийт 110 сурагч хамрагдсан. Судалгаанд оролцогчдын насны дундаж 11–12 бөгөөд дунд сургуульд дэвшин суралцаж буй, бие даан суралцах чадвар идэвхтэй төлөвшиж эхэлдэг насны бүлгийг төлөөлж байна. Судалгаанд хамрагдсан сурагчдын 60 нь эрэгтэй (54.5%), 50 нь эмэгтэй (45.5%) байв. Анги тус бүрийн сурагчдын тоо харьцангуй жигд байсан бөгөөд 6-1 ангид 30, 6-2 ангид 27, 6-3 ангид 29, 6-4 ангид 24 сурагч тус тус хамрагдсан. Иймд түүвэр нь нэг сургуулийн анги хоорондын харьцуулалт хийхэд тохиромжтой бүтэцтэй байна. Судалгаанд хамрагсдыг боломжит түүврийн аргаар (convenience sampling) сонгосон бөгөөд сургуулийн удирдлага, анги удирдсан багш нарын зөвшөөрөлтэйгөөр өгөгдлийг цуглуулсан. Түүнчлэн судалгаа нь нэг цаг хугацаанд өгөгдөл цуглуулсан cross-sectional дизайнтай, өөрөөр хэлбэл судалгаанд хамрагсдын бие даан суралцах чадварыг тодорхой нэг хугацаанд нэг удаа хэмжиж, цаг хугацааны өөрчлөлтийг ажиглаагүй судалгаа (Cohen et al., 2018; Creswell & Creswell, 2018) судалгааны үр дүн нь тухайн үеийн 6-р ангийн сурагчдын бие даан суралцах чадварын өнөөгийн түвшинг илэрхийлнэ.

Судалгааны хэрэгсэл

Энэхүү судалгаанд ашигласан судалгааны хэрэгсэл нь олон улсын судалгааны бие даан сурах чадварын хэмжилтийн онолын хүрээ, асуулгын бүтцийг үндэс болгон судлаачийн боловсруулсан 24 асуулт бүхий өөрөө үнэлэх асуулга юм (Boekaerts, 1999; Panadero, 2017; Zimmerman, 2002). Асуулгыг боловсруулахдаа бэлэн хэмжүүр шууд хуулбарлан ашиглаагүй бөгөөд бие даан сурах чадварыг танин мэдэхүй, мета танин мэдэхүй болон сэтгэл хөдлөлийн бүрэлдэхүүнээр нь үнэлэх зорилгод нийцүүлэн өмнөх судалгаануудад ашиглагдсан асуултуудын агуулга, үзүүлэлтийн логикийг харгалзан боловсруулсан (Dignath & Büttner, 2018; Zimmerman & Schunk, 2011).

Судалгааны асуултууд нь сурагчдын бие даан сурах чадварыг үнэлэх зорилгоор тодорхой, ойлгомжтой, нас сэтгэхүйн онцлогт нийцсэн байдлаар боловсруулагдсан бөгөөд асуулт бүр нэг ойлголтыг илэрхийлэх зарчмыг баримталсан (DeVellis, 2017). Асуултуудын найруулга, утга агуулгыг туршилтад хамрагдаагүй сурагчдад ойлгомжтой эсэхийг урьдчилан шалгаж, шаардлагатай тохиолдолд үгийн сонголт, өгүүлбэрийн бүтцийг сайжруулсан (Creswell, 2014). Ингэснээр судалгааны хэрэгсэл нь сурагчдын өөрийн үнэлгээнд тулгуурлан бие даан сурах чадварын танин мэдэхүй, мета танин мэдэхүй болон сэтгэл хөдлөлийн бүрэлдэхүүнийг ялган хэмжих боломжтой болсон (Panadero, 2017; Zimmerman, 2002).

Энэхүү судалгаанд танин мэдэхүйн чадварыг (ой санамж, анхаарал, асуудал шийдвэрлэх), мета танин мэдэхүйн чадварыг (зорилго, төлөвлөлт, хяналт, хариуцлага), сэтгэл хөдлөлийн чадварыг (сурах хүсэл, сэтгэл хөдлөлийн зохицуулалт) тус тус багтаасан нь онолын хувьд үндэслэлтэй сонголт юм (Dignath & Büttner, 2018; Panadero, 2017). Асуулгын 24 асуулттай бүтэц нь сурагчдын бие даан сурах чадварыг хангалттай өргөн хүрээнд хамруулахын зэрэгцээ дунд сургуулийн насны сурагчдад тохиромжтой, хэт ачаалал үүсгэхгүй хэмжээний асуулгын тоо гэж үздэг судалгааны практикт нийцэж байна (Nunnally & Bernstein, 1994; Schmitt, 2011).

Өгөгдөл боловсруулсан арга

Сурагчид асуултад 5 түвшинт Лейкерт шкалаар (1 – санал нийлэхгүй, 5 – үргэлж тийм) хариулсан бөгөөд хариултын утга нь 0–100 хувийн интервалтайгаар тодорхойлогдсон. Асуулгад хамрагдсан сурагчид өөрсдөө асуулгыг бөглөж, хүйсийн мэдээллээ тэмдэглэсэн. Дараагийн шатанд дескриптив статистик шинжилгээ хийж, бие даан сурах чадварын нийт болон дэд бүрэлдэхүүнүүдийн дундаж (*M*), стандарт хазайлтыг (*SD*) тооцоолсон. Мөн анги хоорондын ялгааг шалгахын тулд one-way ANOVA шинжилгээ, хүйсийн ялгааг үнэлэхийн тулд тохирох статистик тестүүдийг ашигласан.

4. СУДАЛГААНЫ ҮР ДҮН

Судалгаанд хамрагдсан 110 сурагчийн бие даан сурах чадварын бүрэлдэхүүнүүдийн түвшинг тодорхойлох зорилгоор тайлбарлах статистикийн шинжилгээ хийв. Үр дүнгээс харахад танин мэдэхүй, мета танин мэдэхүй болон сэтгэл хөдлөлийн бүрэлдэхүүнүүдийн дундаж оноонууд дунд түвшинд илэрч, хоорондоо ойролцоо утгатай байв. Танин мэдэхүйн бүрэлдэхүүний дундаж оноо бусад бүрэлдэхүүнүүдтэй харьцуулахад тоон утгын хувьд бага зэрэг өндөр байсан боловч уг үр дүн нь зөвхөн тухайн түүврийн тайлбарлах статистикт үндэслэсэн ажиглалт бөгөөд сурагчдын өмнөх сургалтын шатанд олж авсан чадвартай холбон тайлбарлах нотолгоо энэ судалгаанд илрээгүй болно.

Анги хоорондын ялгааг шалгах зорилгоор нэг хүчин зүйлийн дисперсийн шинжилгээ (one-way ANOVA) хийж, бие даан сурах чадварын танин мэдэхүй, мета танин мэдэхүй, сэтгэл хөдлөлийн бүрэлдэхүүнүүд болон нийт оноонд статистикийн ач холбогдолтой ялгаа илрээгүй ($p > .05$). Мөн сэтгэл хөдлөлийн хэмжээг илэрхийлэх η^2 утгууд бага гарсан нь илэрсэн ялгаанууд практик ач холбогдол багатай байгааг харуулж байна. Иймд 6-р ангийн дөрвөн бүлгийн сурагчдын бие даан сурах чадварын түвшин анги хооронд харьцангуй жигд байгааг уг шинжилгээний үр дүн харуулж байна.

Судалгааны асуулгын найдвартай байдлын шинжилгээ

Сурагчдын бие даан сурах чадварыг хэмжих зорилгоор 24 асуултаас бүрдэх өөрөө үнэлэх асуулга ашиглав. Асуулга нь дараах гурван үндсэн чадварыг хамарна. Үүнд:

- Танин мэдэхүйн чадвар (Q1–Q9): ой санамж, анхаарал төвлөрөл, асуудал шийдвэрлэх чадвар
- Мета танин мэдэхүйн чадвар (Q10–Q18): зорилго тодорхойлох, төлөвлөх, өөрийгөө хянах, хариуцлагатай байх чадвар
- Сэтгэл хөдлөлийн чадвар (Q19–Q24): сурах хүсэл эрмэлзэл, сэтгэл хөдлөлийн зохицуулалт

Шинжилгээний үр дүнгээр дэд чадваруудын Cronbach's α утгууд 0.75–0.82 хооронд хэлбэлзэж, нийт хэмжүүрийн α = 0.86 гарсан нь хэмжүүрийн дотоод тогтвортой байдал сайн түвшинд байгааг харуулж байна. Судалгааны арга зүйн судалгаанд Cronbach's α ≥ 0.70 байх нь нийгмийн шинжлэх ухааны судалгаанд хүлээн зөвшөөрөгдөх найдвартай байдлын доод босго гэж үздэг (Nunnally & Bernstein, 1994; Tavakol & Dennick, 2011). Иймд энэхүү асуулгыг цаашдын статистик шинжилгээнд ашиглахад найдвартай хэмжүүр гэж дүгнэв (хүснэгт 1).

Хүснэгт 1. Судалгааны асуулгын дотоод найдвартай байдлын шинжилгээ

Хэмжүүр	Асуултын тоо	Cronbach's α
Танин мэдэхүйн чадвар (Q1–Q9)	9	0.78
Мета танин мэдэхүйн чадвар (Q10–Q18)	9	0.82
Сэтгэл хөдлөлийн чадвар (Q19–Q24)	6	0.75
Нийт бие даан сурах чадвар	24	0.86

Танин мэдэхүйн чадварын тайлбар статистик (M, SD)

Хүснэгт 2-т 6-р ангийн дөрвөн бүлгийн сурагчдын танин мэдэхүйн чадварын тайлбар статистикийг харууллаа. Үр дүнгээс харахад бүлгүүдийн дундаж оноо ойролцоо түвшинд байна. Тухайлбал, 6-1 ангийн сурагчдын дундаж оноо $M = 29.77$ ($SD = 8.26$), 6-2 ангид $M = 29.32$ ($SD = 9.30$), 6-3 ангид $M = 28.17$ ($SD = 8.16$), харин 6-4 ангид $M = 29.64$ ($SD = 9.26$) байна.

Дундаж онооны хамгийн өндөр үзүүлэлт 6-1 болон 6-4 ангид ажиглагдсан боловч стандарт хазайлтууд (SD ≈ 8–9) ялимгүй өндөр байгаа нь тухайн анги дотор сурагчдын танин мэдэхүйн чадварын түвшин жигд бус, хувь хүн хоорондын ялгааг илтгэж байна. Нийт 110 сурагчийн өгөгдөлд тулгуурлан авч үзвэл 6-р ангийн сурагчдын танин мэдэхүйн чадвар дунд түвшинд бөгөөд анги хоорондын ялгаа нь тоон хувьд бага байгааг энэхүү тайлбар статистик харуулж байна. Эдгээр үр дүн нь дараагийн шатанд хийсэн нэг хүчин зүйлийн дисперсийн шинжилгээнд (one-way ANOVA) бүлэг хооронд статистикийн ач холбогдолтой ялгаа илрээгүй гэсэн дүгнэлттэй нийцэж байна (хүснэгт 2).

Нэг хүчин зүйлийн дисперсийн шинжилгээний үр дүнд 6-р ангийн дөрвөн бүлгийн сурагчдын танин мэдэхүйн чадварын дундаж оноонд статистикийн ач холбогдолтой ялгаа илрээгүй ($F(3, 106) = 0.21$, $p = .891$). Эффектийн хэмжээ маш бага ($\eta^2 = .006$) байгаа нь бүлэг хоорондын ялгаа практик ач холбогдолгүй болохыг харуулж байна.

Иймд 6-р ангийн сурагчдын ой санамж, анхаарал төвлөрөл, асуудал шийдвэрлэх чадвар анги хооронд харьцангуй жигд түвшинд байна гэж дүгнэж болно (Хүснэгт 3).

Хүснэгт 2. 6-р ангийн сурагчдын танин мэдэхүйн чадварын тайлбар статистик ба бүлэг хоорондын ялгааны шинжилгээ (One-way ANOVA)

Анги / Эх үүсвэр	эр	эм	n	Танин мэдэхүйн чадвар, *M* (*SD*)
6-1	17	13	30	29.77 (8.26)
6-2	15	12	27	29.32 (9.30)
6-3	15	14	29	28.17 (8.16)
6-4	13	11	24	29.64 (9.26)

Тайлбар: *M* = дундаж утга (Mean), *SD* = стандарт хазайлт (Standard Deviation)

Мета танин мэдэхүйн чадварын тайлбар статистикийн тайлбар (M, SD)

6-р ангийн дөрвөн бүлгийн сурагчдын мета танин мэдэхүйн чадварын тайлбар статистикийг хүснэгтэд үзүүллээ. Мета танин мэдэхүйн чадвар нь сурагчдын зорилго тодорхойлох, суралцах үйл ажиллагаагаа төлөвлөх, хэрэгжилтийг хянах, өөртөө хариуцлага хүлээх чадваруудыг хамарсан үзүүлэлт юм.

Мета танин мэдэхүйн чадварын тайлбар статистикийн үр дүнгээс харахад 6-р ангийн дөрвөн бүлгийн сурагчдын дундаж оноо ойролцоо түвшинд байна. Үр дүнгээс харахад бүлэг тус бүрийн дундаж оноо хоорондоо ойролцоо түвшинд байна. Энэ нь 6-р ангийн сурагчдын мета танин мэдэхүйн чадвар анги хооронд ихээхэн ялгаатай биш, харьцангуй жигд түвшинд байгааг илтгэнэ. Харин стандарт хазайлтын (*SD*) утгууд нь бүлэг бүрд дунд зэргийн хэмжээнд байгаа нь нэг анги дотор сурагчдын өөрийгөө төлөвлөх, хянах, хариуцлага хүлээх чадвар хувь хүнээсээ шалтгаалан ялгаатай байгааг харуулж байна.

Нэг хүчин зүйлийн дисперсийн шинжилгээний үр дүнгээр 6-р ангийн дөрвөн бүлгийн сурагчдын мета танин мэдэхүйн чадварын дундаж оноонд статистикийн ач холбогдолтой ялгаа илрээгүй ($F(3, 110) = 1.92$, $p > .05$). Эффектийн хэмжээ бага түвшинд ($\eta^2 = .05$) байгаа нь сурагчдын зорилго тодорхойлох, төлөвлөх, өөрийгөө хянах, хариуцлагатай байх чадвар анги хооронд харьцангуй жигд түвшинд байгааг илтгэнэ.

Сэтгэл хөдлөлийн чадварын тайлбар статистик (M, SD)

Сэтгэл хөдлөлийн чадвар нь сурах хүсэл эрмэлзэл (Q19–Q21), сэтгэл хөдлөлийн зохицуулалт (Q22–Q24) гэсэн 2 дэд чадвараас бүрдэж, нийт 6 асуултаар хэмжив (Хүснэгт 3).

*Хүснэгт 3. 6-р ангийн сурагчдын мета танин мэдэхүйн чадварын тайлбар статистик ба бүлэг хоорондын ялгааны шинжилгээ (One-way ANOVA)***

Анги	**эр**	**эм**	**n**	**Мета танин мэдэхүйн чадвар, *M* (*SD*)**
6-1	17	13	30	30.52 (8.59)
6-2	15	12	27	29.68 (8.69)
6-3	15	14	29	29.60 (8.31)
6-4	13	11	24	26.24 (8.44)

Тайлбар: *M* = дундаж утга (Mean), *SD* = стандарт хазайлт (Standard Deviation)

Нэг хүчин зүйлийн дисперсийн шинжилгээний үр дүнгээр 6-р ангийн дөрвөн бүлгийн сурагчдын Сэтгэл хөдлөлийн чадварын дундаж оноонд статистикийн ач холбогдолтой ялгаа илрээгүй ($F(3, 106) = 0.51$, $p > .05$). Эффектийн хэмжээ маш бага ($\eta^2 = .014$) байгаа нь бүлэг хоорондын ялгаа практик ач холбогдолгүй болохыг харуулж байна. Энэ нь сурагчдын сурах хүсэл эрмэлзэл, сэтгэл хөдлөлийн зохицуулалтын түвшин анги хооронд харьцангуй жигд байгааг илтгэнэ (Хүснэгт 4).

*Хүснэгт 4. 6-р ангийн сурагчдын сэтгэл хөдлөлийн чадварын тайлбар статистик ба бүлэг хоорондын ялгааны шинжилгээ (One-way ANOVA)***

Анги	**эр**	**эм**	**n**	**Сэтгэл хөдлөлийн чадвар, *M* (*SD*)**
6-1	17	13	30	21.34 (4.18)
6-2	15	12	27	20.96 (4.52)
6-3	15	14	29	20.41 (4.07)
6-4	13	11	24	21.12 (4.36)

Тайлбар: *M* = дундаж утга (Mean), *SD* = стандарт хазайлт (Standard Deviation)

6-р ангийн дөрвөн бүлгийн (6-1, 6-2, 6-3, 6-4) сурагчдын бие даан сурах чадварын нийт онооны ялгааг шалгах зорилгоор нэг хүчин зүйлийн дисперсийн шинжилгээ (one-way ANOVA) хийв. Шинжилгээний үр дүнгээр бүлгүүдийн хооронд статистикийн ач холбогдолтой ялгаа илрээгүй ($F(3, 108) = 0.11$, $p = .952$). Нөлөөллийн хэмжээ (effect size) $\eta^2 = .003$ гарсан нь бүлэг хоорондын ялгаа маш бага түвшинд байгааг харуулж байна (Cohen, 1988). Иймээс 6-р ангийн дөрвөн бүлгийн сурагчдын бие даан сурах чадварын нийт түвшин хоорондоо ойролцоо, ялгаагүй байна гэж дүгнэв (Хүснэгт 5).

Хүснэгт 5. Бие даан сурах чадварын нийт онооны бүлэг хоорондын ялгаа, 6-р ангийн сурагчдын бие даан сурах чадварын нийт онооны бүлэг хоорондын ялгааны шинжилгээ (One-way ANOVA)

Хувьсагч	SS	df	MS	F	p	η^2
Бүлэг хооронд	97.07	3	32.36	0.11	.952	.003
Бүлэг дотор	30178.80	108	284.71			
Нийт	30275.86	110				

5. ХЭЛЭЛЦҮҮЛЭГ, ДҮГНЭЛТ

Энэхүү судалгааны үр дүнгээр дунд сургуулийн 6-р ангийн сурагчдын бие даан суралцах чадвар нь танин мэдэхүй, мета танин мэдэхүй болон сэтгэл хөдлөлийн гурван бүрэлдэхүүний хүрээнд харьцангуй жигд түвшинд илэрч, анги хооронд статистикийн ач холбогдолтой ялгаа илрээгүй. Энэ үр дүн нь бие даан суралцах чадварыг олон бүрэлдэхүүнт, харилцан уялдаатай цогц чадвар хэмээн тайлбарладаг орчин үеийн өөрийн удирдлагатай суралцахуйн онолын байр суурийг эмпирик өгөгдлөөр дэмжиж байна (Panadero, 2017; Zimmerman, 2002).

Судалгааны үр дүн нь бие даан суралцах чадварын бүрэлдэхүүнүүдийг (танин мэдэхүйн, мета танин мэдэхүйн, сэтгэл хөдлөлийн) суралцах үйл ажиллагааг бүхэлд нь зохицуулдаг нэгдмэл систем хэмээн авч үзэх онолын шаардлагыг бататгалаа. Бие даан суралцах чадвар нь зөвхөн танин мэдэхүйн стратеги эзэмшсэн байдал бус, харин өөрийн суралцах үйл явцыг төлөвлөх, хянах, сэтгэл хөдлөлөө зохицуулах механизмын уялдаанд илэрдэг гэсэн тайлбартай нийцэж байна (Boekaerts, 1999; Zimmerman & Schunk, 2011). Мөн нэг ижил сургалтын орчинд суралцаж буй сурагчдын дунд бие даан суралцах чадвар жигд илэрч буй нь уг чадварын хөгжилд хувь хүний ялгаанаас гадна сургалтын орчин, сургалтын зохион байгуулалтын нөлөө чухал болохыг харуулж байна. Энэ нь өөрийн удирдлагатай суралцахуйн хөгжлийг хувь хүний дотоод хүчин зүйлсийн үр дүн бус, орчны дэмжлэгтэй харилцан үйлчилдэг процесс гэж үздэг орчин үеийн онолын тайлбарыг дэмжиж байна (Dignath & Büttner, 2018; Panadero, 2017).

Практик түвшинд авч үзвэл, судалгааны үр дүн нь дунд сургуулийн сургалтын орчинд бие даан суралцах чадварыг хөгжүүлэх ажлыг сурагчийн хувь хүний хичээл зүтгэлд даатгах бус, харин сургалтын зорилго, даалгавар, үнэлгээний зохион байгуулалттай уялдуулсан системтэй дэмжлэг шаардлагатайг харуулж байна. Өөрөөр хэлбэл, сурагчдад зорилгоо тодорхойлох, суралцах үйл явцаа төлөвлөх, өөрийн ахицыг хянах боломж олгодог сургалтын арга зүй нь бие даан суралцах чадварыг хөгжүүлэхэд бодитой нөлөө үзүүлдэг болохыг өмнөх судалгаанууд мөн нотолсон байдаг (Schunk & Zimmerman, 2016; Zimmerman, 2002). Түүнчлэн сэтгэл хөдлөлийн зохицуулалт, сурах хүсэл эрмэлзлийг дэмжсэн сургалтын орчин бүрдүүлэх нь танин мэдэхүй болон мета танин мэдэхүйн стратегийн бодит хэрэглээг дэмждэг болохыг судалгааны үр дүн харуулж байна. Энэ нь сэтгэл хөдлөлийн хүчин зүйлсийг суралцах үйл ажиллагааны нөхцөлдүүлэгч, дэмжигч хүчин зүйл гэж үздэг судалгааны дүгнэлтүүдтэй нийцэж байна (Boekaerts, 1999; Mega et al., 2014). Иймд эх хэл, нийгэм судлал зэрэг хичээлүүдийн хүрээнд эргэцүүлэл, өөрийн үнэлгээнд суурилсан даалгавар ашиглах, сурагчдын суралцах үйл явцыг ухамсарлах боломж олгох сургалтын зохион байгуулалт нь бие даан суралцах чадварыг бодит сургалтын практикт хөгжүүлэх үр дүнтэй арга болох боломжтой юм (Dignath & Büttner, 2018).

Судалгааны үр дүнг Монгол сурагчдын суралцах орчны онцлогтой холбон авч үзвэл, анги хоорондын ялгаа бага илэрсэн нь Монголын ерөнхий боловсролын сургуулиудад түгээмэл ажиглагддаг багш төвтэй сургалтын зохион байгуулалт, сургалтын ижил хөтөлбөр, үнэлгээ зэрэг нь сурагчдын суралцах зан төлөвт нөлөөлж байгаатай холбоотой байж болох юм. Багш төвтэй сургалтын орчинд сурагчдын өөрийн удирдлагатай суралцах чадвар нь хувь хүний түвшинд ялгарахаас илүүтэй ангийн түвшинд ижилсэх хандлагатай байдгийг олон улсын судалгаанд мөн дурдсан байдаг (OECD, 2019; Zimmerman, 2002). Түүнчлэн Монгол хүүхдүүдийн хувьд хамт олонч байдал, багшийн зааврыг дагах, сургалтын дүрэм журмыг баримтлах хандлага харьцангуй өндөр байдаг нь суралцах үйл явцыг бие даан зохицуулах чадварын илрэл анги дотор жигд харагдах нөхцөлийг бүрдүүлдэг гэж тайлбарлах боломжтой. Энэ нь соёлын онцлог суралцах зан үйлд нөлөөлдөг болохыг харуулсан соёл хоорондын судалгааны дүгнэлтүүдтэй нийцэж байна (Hofstede, 2011; OECD, 2018). Нөгөө талаас, дунд сургуулийн нэгдүгээр анги буюу 6-р ангийн сурагчдын өөрийн суралцах үйл явцыг бүрэн бие даан төлөвлөж, хянах чадвар хараахан тогтворжоогүй байдаг нь олон

улсын судалгаанд нийтлэг ажиглагддаг үзэгдэл бөгөөд энэхүү судалгаанд мөн адил илэрсэн (Dignath & Büttner, 2018; Panadero, 2017).

Судалгааны хязгаарлалт

Энэхүү судалгаа нь дунд сургуулийн 6-р ангийн сурагчдыг хамарсан, нэг цаг хугацаанд өгөгдөл цуглуулсан тул үр дүнг бусад сургууль, бүс нутаг, насны бүлэгт шууд ерөнхийлөн тайлбарлахад хязгаарлалттай. Мөн өгөгдлийг зөвхөн сурагчдын өөрөө үнэлэх асуулгад тулгуурлан цуглуулсан нь тэдний бодит зан үйлийн илрэлийг бүрэн тусгах боломжийг хязгаарлаж болзошгүй. Түүнчлэн судалгаанд эцэг эх, асран хамгаалагч, багш нарын үнэлгээ, ажиглалтын мэдээлэл хамрагдаагүй нь сурагчдын бие даан сурах чадварт орчны нөлөөг олон талаас нь шинжлэх боломжийг хязгаарласан болно.

Цаашдын судалгаанд бие даан суралцах чадварыг өөр өөр насны бүлэг, сургуулийн төрөл, бүс нутгийн ялгаатай орчинд харьцуулан судлах, мөн тоон судалгааг чанарын аргаар (ярилцлага, ажиглалт) баяжуулж, сурагчдын бодит суралцах зан үйлийн илрэлийг гүнзгий шинжлэх нь зүйтэй. Түүнчлэн бие даан суралцах чадварыг хөгжүүлэхэд чиглэсэн сургалтын тодорхой арга зүйн үр нөлөөг туршилтын судалгаагаар шалгах нь цаашдын судалгааны чухал чиглэл болох боломжтой.

ТАЛАРХАЛ

Энэхүү судалгааг хийхэд дэмжлэг үзүүлсэн “Шинэ Монгол” сургуулийн 31-р үеийн анги удирдсан багш нар болон НУЗАН-ийн хамт олондоо баярлалаа.

НОМ ЗҮЙ

Alexander, R., Rose, J., & Woodhead, C. (1992). *Curriculum organisation and classroom practice in primary schools: A discussion paper*. Department of Education and Science. https://dera.ioe.ac.uk/id/eprint/4373/

Байгаль, Ө. (2002). Сургалтаар дамжуулан өсвөр насны хүүхдийн өөрийгөө удирдах чадварыг хөгжүүлэх нь. *Боловсрол судлал*, (31).

Bates, I., & Wilson, P. (2002). Family and education: Supporting independent learning. *Learning and Skills Research*, *6*(1), 1–13.

Bishop, G. (2006). True independent learning—An andragogical approach. *The Language Learning Journal*, *33*, 40–46. https://doi.org/10.1080/09571730685200141

Black, P., McCormick, R., James, M., & Pedder, D. (2006). Learning how to learn and assessment for learning. *Research Papers in Education*, *21*(2), 119–132. https://doi.org/10.1080/02671520600615612

Boekaerts, M. (1997). Self-regulated learning: A new concept embraced by researchers, policy makers, educators, teachers, and students. *Learning and Instruction*, *7*(2), 161–186. https://doi.org/10.1016/S0959-4752(96)00015-1

Boekaerts, M. (1999). Self-regulated learning: Where we are today. *International Journal of Educational Research*, *31*(6), 445–457. https://doi.org/10.1016/S0883-0355(99)00014-2

Candy, P. C. (1991). *Self-direction for lifelong learning: A comprehensive guide to theory and practice*. Jossey-Bass.

Cohen, J. (1988). *Statistical power analysis for the behavioral sciences* (2nd ed.). Lawrence Erlbaum Associates. https://doi.org/10.4324/9780203771587

Cohen, L., Manion, L., & Morrison, K. (2018). *Research methods in education* (8th ed.). Routledge. https://doi.org/10.4324/9781315150017

Creswell, J. W. (2014). *Research design: Qualitative, quantitative, and mixed methods approaches* (4th ed.). SAGE Publications.

Creswell, J. W., & Creswell, J. D. (2018). *Research design: Qualitative, quantitative, and mixed methods approaches* (5th ed.). SAGE Publications.

DeVellis, R. F. (2017). *Scale development: Theory and applications* (4th ed.). SAGE Publications.

Dignath, C., & Büttner, G. (2018). Components of fostering self-regulated learning among students. *Metacognition and Learning*, *13*(2), 211–246. https://doi.org/10.1007/s11409-018-9186-x

Efklides, A. (2019). Gifted students and self-regulated learning. *High Ability Studies*, *30*(1–2), 79–102. https://doi.org/10.1080/13598139.2018.1556069

Энхтувшин, С. (2009). Суралцахуйн үзэл баримтлалд гарч буй хувьсал. *Боловсрол судлал*, (35).

Harlen, W., & Deakin Crick, R. (2002). *A systematic review of the impact of summative assessment and tests on students' motivation for learning*. EPPI-Centre, Social Science Research Unit, Institute of Education, University of London. https://eppi.ioe.ac.uk/cms/Default.aspx?tabid=107

Hattie, J. (2015). The applicability of Visible Learning to higher education. *Scholarship of Teaching and Learning in Psychology*, *1*(1), 79–91. https://doi.org/10.1037/stl0000021

Higgins, S., Baumfield, V., & Hall, E. (2005). *A meta-analysis of the impact of the implementation of thinking skills approaches on teaching and learning*. EPPI-Centre, Social Science Research Unit, Institute of Education, University of London. https://eppi.ioe.ac.uk/cms/Default.aspx?tabid=335

Hofstede, G. (2011). Dimensionalizing cultures: The Hofstede model in context. *Online Readings in Psychology and Culture*, *2*(1). https://doi.org/10.9707/2307-0919.1014

Жаргалсайхан, О. (2003). Бие даахуйн уур амьсгалыг яаж төлөвшүүлж, хамгаалах вэ. *Боловсрол судлал*.

MacBeath, J. (1993). *Learning for yourself*. Strathclyde Regional Council.

Mega, C., Ronconi, L., & De Beni, R. (2014). What makes a good student? How emotions, self-regulated learning, and motivation contribute to academic achievement. *Journal of Educational Psychology*, *106*(1), 121–131. https://doi.org/10.1037/a0033546

Nunnally, J. C., & Bernstein, I. H. (1994). *Psychometric theory* (3rd ed.). McGraw-Hill.

OECD. (2018). *The future of education and skills: Education 2030*. OECD Publishing. https://www.oecd.org/education/2030-project/contact/OECD_Learning_Compass_2030_concept_note.pdf

OECD. (2019). *OECD learning compass 2030: A series of concept notes*. OECD Publishing. https://www.oecd.org/education/2030-project/teaching-and-learning/learning/learning-compass-2030/

OECD. (2021). *OECD learning compass 2030: A series of concept notes*. OECD Publishing. https://www.oecd.org/education/2030-project/teaching-and-learning/learning/learning-compass-2030/

Орнштейн, А. (2003). Идэвхтэй сургалтын стратеги: Багшлах, суралцах. *Боловсрол судлал*, (35).

Panadero, E. (2017). A review of self-regulated learning: Six models and four directions for research. *Frontiers in Psychology*, *8*, Article 422. https://doi.org/10.3389/fpsyg.2017.00422

Panadero, E., Jonsson, A., & Botella, J. (2018). Effects of self-assessment on self-regulated learning and self-efficacy: Four meta-analyses. *Educational Research Review*, *22*, 74–98. https://doi.org/10.1016/j.edurev.2017.08.004

Schunk, D. H., & Zimmerman, B. J. (2016). *Handbook of self-regulation of learning and performance* (2nd ed.). Routledge. https://doi.org/10.4324/9780203839010

Tavakol, M., & Dennick, R. (2011). Making sense of Cronbach's alpha. *International Journal of Medical Education*, *2*, 53–55. https://doi.org/10.5116/ijme.4dfb.8dfd
Тогтохмаа, З. (2014). "Насан туршийн боловсрол" нэр томьёоны тухайд. *Боловсрол судлал*, (12).
Winne, P. H., & Jamieson-Noel, D. (2002). Exploring students' calibration of self reports about study tactics and achievement. *Contemporary Educational Psychology*, *27*(4), 551–572. https://doi.org/10.1016/S0361-476X(02)00006-1
Zimmerman, B. J. (2002). Becoming a self-regulated learner: An overview. *Theory Into Practice*, *41*(2), 64–70. https://doi.org/10.1207/s15430421tip4102_2
Zimmerman, B. J., & Schunk, D. H. (2011). *Handbook of self-regulation of learning and performance*. Routledge. https://doi.org/10.4324/9780203839010
Zimmerman, B. J., & Schunk, D. H. (2018). *Handbook of self-regulation of learning and performance* (2nd ed.). Routledge. https://doi.org/10.4324/9781315697048

Хавсралт

Хариултын тайлбар:

1 - санал нийлэхгүй байна. / 0-20 хувь/
2 - заримдаа /20-40 хувь/
3 - бараг л санал нэг байна. /40-60 хувь/
4 - ихэнхдээ ийм байдаг. /60-80 хувь/
5 - үргэлж ийм байдаг. /80-100 хувь/

Анги: 6-... Хүйс:.....

1. Танин мэдэхүйн чадвар

1.1 Ой санамж, ой тогтоолт

1. Би багшийн асуусан асуултыг нэг удаа сонсоод ойлгодог. **(1 2 3 4 5)**
2. Би шинэ мэдээллийг богино хугацаанд тогтоож, дараа нь санаж чаддаг.**(1 2 3 4 5)**
3. Хичээл дээр сурсан зүйлээ дараагийн нь эргэн санахад надад амархан байдаг. **(12 3 4 5)**

1.2 Анхаарал төвлөрөл

1. Би хичээл дээрээ өөр зүйлд сатаардаггүй. **(1 2 3 4 5)**
2. Бусдын ярих, үймүүлэх нь надад саад болдоггүй. **(1 2 3 4 5)**
3. Би их даалгавар хийж байх үед ч анхаарлаа тогтвортой хадгалж чаддаг. **(1 2 3 4 5)**

1.3 Асуудал шийдвэрлэх чадвар

1. Би өөрөө шийдвэр гаргаж чаддаг. **(1 2 3 4 5)**
2. Өөрт тулгарсан асуудлыг би өөрөө шийддэг. **(1 2 3 4 5)**
3. Шаардлагатай үед би асуудлаа шийдэхэд тохирох хүнээс тусламж авдаг. **(1 2 3 4 5)**

2. Мета танин мэдэхүйн чадвар

2.1 Зорилго, төлөвлөгөө

1. Би ирээдүйн зорилгоо тодорхойлсон. **(1 2 3 4 5)**
2. Би цагийн төлөвлөлт сайтай. **(1 2 3 4 5)**
3. Хичээл, даалгавар бүрийн өмнө ямар зорилготой ажиллаж буйгаа ойлгож, ухамсарладаг. **(1 2 3 4 5)**

2.2 Төлөвлөгөөний хэрэгжилтийг хянах, сайжруулах чадвар

1. Би төлөвлөсөн ажлынхаа явцыг үе шат бүрд хянаж чаддаг. **(1 2 3 4 5)**
2. Би алдаа гаргасан үедээ юу нь буруу болсныг өөрөө тодорхойлж, засахыг хичээдэг. **(1 2**

3 4 5)

3. Зорилгодоо хүрэхийн тулд хэрэгтэй бол төлөвлөгөөгөө өөрчилж сайжруулдаг. **(1 2 3 4 5)**

2.3 Хариуцлагатай байх чадвар

1. Би даалгавраа цаг тухайд нь биелүүлэхийг хичээдэг. **(1 2 3 4 5)**
2. Өөрийн суралцах үйлд би өөрөө хариуцлага хүлээдэг. **(1 2 3 4 5)**
3. Даалгавраа орхихгүй, эхэлсэн ажлаа дуусгахыг би чухалд тооцдог. **(1 2 3 4 5)**

3. Сэтгэл хөдлөлийн чадвар

3.1 Сурах хүсэл эрмэлзэл

1. Шинэ зүйл сурахад би идэвхтэй оролцох дуртай. **(1 2 3 4 5)**
2. Сурах нь надад үнэ цэнтэй, хэрэгтэй санагддаг. **(1 2 3 4 5)**
3. Надад бэрхшээл тулгарсан ч суралцахаас ухардаггүй. **(1 2 3 4 5)**

3.2 Мэдрэмж, сэтгэл хөдлөлөө ойлгох чадвар

1. Хичээл дээр юу мэдэрч байгаагаа ойлгож, илэрхийлж чаддаг. **(1 2 3 4 5)**
2. Сэтгэл санаагаа тайван байлгаж, суралцахдаа анхаардаг**. (1 2 3 4 5)**
3. Бэрхшээл тулгарсан үед өөрийгөө зоригжуулж, урам өгдөг. **(1 2 3 4 5)**

ЗОХИОГЧИЙН ТАНИЛЦУУЛГА

Д.Отгонтуяа (Ph.D). Боловсрол, төрийн удирдлага, бүтээмжийн судалгааны чиглэлээр эрдэм шинжилгээний судалгаа хийж буй судлаач юм. 2023 оноос хойш ЕБС-ийн багш нарын ажил-амьдралын тэнцвэр, дунд сургуулийн сурагчдын бие даан сурах чадвар болон түүнд нөлөөлөх хүчин зүйлсийг судалсан бөгөөд сүүлийн жилүүдэд боловсролын чанар, суралцахуйд чиглэсэн эмпирик судалгаанд төвлөрч байна.

Э.Эрдэнэтуяа. МУИС-ийн Монгол хэл бичгийн багшийн анги, 2020 онд бакалавр хамгаалсан. Монгол хэлний багшаар 6 дахь жилдээ ажиллаж байна. “ЕБС-ийн багш нарын ажил-амьдралын тэнцвэрийн судалгаа”-г 2025 онд бусад багш нартай хамтран бичиж хэлэлцүүлсэн. Судалгааны ажлын чиглэл “Сурагчийн бие даан суралцахуй”, Сурлагын амжилтад нөлөөлж буй хүчин зүйлс” зэрэг болно.

Open Access
Education journal
Vol. 2 (2026), No. 1

ISSN 3007-2549

Journal of
EDUCATION

Article

An Analysis of Self-Directed Learning Skills among Middle School Students: Cognitive, Metacognitive, and Affective Skills

Otgontuya Dorjkhuu[1], Erdentetuya Enkhbayar[2]

[12]*Education Shine Mongol secondary school, Ulaanbaatar,Mongolia*

ARTICLE INFO

History:
Received: 2026-01-14
Revised: 2026-02-25
Published: 2026-06-04

Keywords:
Self-directed learning
Cognitive skills
Metacognitive skills
Affective skills

ABSTRACT

Self-directed learning is widely recognized as a core competence in secondary education; however, empirical evidence on its multidimensional structure remains limited in under-researched educational contexts. In particular, quantitative studies examining cognitive, metacognitive, and affective components of self-directed learning among middle school. This study investigated the level of self-directed learning skills among 110 sixth-grade students from four classes at a private secondary school in Mongolia. Data were collected using a self-directed learning skills questionnaire grounded in established theoretical frameworks. The instrument demonstrated good internal consistency, with a Cronbach's alpha of 0.86 for the overall scale and acceptable reliability for the subscales ($\alpha = 0.75–0.82$). Descriptive statistics and one-way analyses of variance (ANOVA) were employed to examine differences in self-directed learning skills across classes. The results showed that students' cognitive, metacognitive, and affective self-directed learning skills, as well as the overall self-directed learning score, were at comparable levels across the four classes. One-way ANOVA revealed no statistically significant differences among classes for any component ($p > .05$). Effect size estimates (η^2) were small, indicating minimal practical differences between groups. These findings provide empirical evidence on the multidimensional profile of self-directed learning skills among sixth-grade students within the studied educational context. The results should be interpreted within the limits of the study sample and offer a data-driven basis for further research on self-directed learning in secondary education.

©2026 Author(s). This is an open access article under the CC BY 4.0 license (https://creativecommons.org/licenses/by/4.0/).

Corresponding author. Email:*d.otgontuya@shinemongol.edu.mn*
ORCID: https://orcid.org/0009-0007-4340-7846